



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 55

Алтай

Орон нутгийн өмчийн албыг татан буулгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.4 дэх заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 03- ны өдрийн 9 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Орон нутгийн өмчийн албыг татан буулгасугай.

2. Тус албыг татан буулгасантай холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалтын хүрээнд албаны шинэчилсэн бүтэц орон тоо, удирдлага зохион байгуулалтын асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/- д даалгасугай.

3. Уг тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 04 дүгээр сарын 29- ний өдрийн 16 дугаар тогтоол, 2014 оны 03 дугаар сарын 31- ний 27 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болгосугай..

ДАРГА

Т.ГАНЗОРИГ